

ТАЛ НУТГИЙН ЁС СУРТАХУУНЫГ ҮНДЭСЛЭГЧ

Орчуулсан С.Оджүү

Монгол -татаарууд буюу христийн ертөнцөд "Тартаарууд" гэгдэгчдийг хэдэн зууны турш "тамын элч", соёл иргэншлийн дайснууд, харин тэдний удирдагч, их эзэн Чингис хаан олон үеийн Европ, азичуудын хувьд эвдэн сүйтгэгч мухар сохор хүчний биелэл, Бурхны ташуур, хоёрдахь Аттила байсан юм. Тийн байтал XX зууны эцсээр "өнгөрч байгаа мянганы хүн" гэсэн цолны төлөө янз бүрийн уралдаан тэмцээн ихээхэн газар авав. Тэгтэл нөгөөх Бурхны ташуур гэгдэгч хамгийн ихээр нэрлэгдэх болсон байна. Дэлхий ертөнцийг орчин цагийн "даяаршил бүхий нэг тосгон" болгон хувиргахад энэхүү бичиг үсэг үл мэдэх нүүдэлчин бусдаас ихийг хийж бүтээснийг "Вашингтон пост"-д бичсэн байлаа. Ингэхлээр Монголын эзэнт гүрэн гэж юу байв, 800 жилийн өмнө түүнийг байгуулсан Чингис хаан гэж хэн байгаа вэ?

2003 онд "Хүний генетикийн Америк сэтгүүл" -д Евразийн өнцөг булан бүрийн 2000 хүний ДНК-г шинжилсэн хэсэг эрдэмтдийн судалгааны дүнг нийтэлжээ. Судалгаанд хамрагдсан олон хүний У хромосом ганцхан гэр бүлийнх байж болохоор тийм их төсөөтэй байсан нь гайхаш төрүүлэв. Ойролцоогоор тооцоолоход энэхүү "гэр бүлд" Каспийн Тэнгисээс Номхон далай хүртэлх газар орны 16 сая хүн эдүгээ хамаарч байгаа ажээ. Эл үзэгдлийг XII-XIII зууны зааг орчимд амьдарч, асар хүчирхэг генетикийн материалыг Евразийн талаар тархаасан нэгэн өндөр өвөг байснаар л зөвхөн тайлбарлаж болох юм байна.

Манай тив нутгийнхны энэхүү өндөр өвөг байж болох хамгийн магадлалтай хүн бол өдий төдий хатад болон татвар эмсийн эзэн, "нийтлэг генийн нутаг оронтой" яв цав нийцэж байгаа тэрхүү эзэнт гүрнийг үндэслэн байгуулагч Чингис хаан мөн байна гэсэн дүгнэлтэнд биологичид хүрсэн болой.

ХААДЫН ХААН

Монголын эзэнт гүрэн¹, түүнийг үндэслэгч хоёр бол нам, Ленин хоёр гэгч ойлголтууд шиг салшгүй юм. Өнчин ганц "Талын чоно" их түүхийн хамгийн хүчирхэг дарангуйлагчдынх яаж болов оо гэдгийг ойлгож авна гэдэг бол өчүүхэн жижиг нүүдэлчин аймаг нэн бага хугацааны дотор "Яагаад гэдэг, нь огт ойлгомжгүйгээр" ертөнцийн талын эзэд болтлоо гэнэтхэн өсөж өндийсний нууцыг тайлна гэсэн үг юм. 1206 оны намар буюу бар жилд Дорнод Монголын Онон голын эх хавьцаа дэлхийн түүхийн эргэлт болсон үйл явдлуудын нэгэн болж дал нутгийн ихэс дээдсийн чуулган буюу эх хуралдай хуралджээ. "Эсгий гэрт амьдрагсад" нэгэн аймгийнхаа удирдагч Тэмүүжинг хаадын хаан болгон өргөмжилж, Чингис хаан хэмээн нэрлэх болсон байна. "Ихэс ноёд цөм цуглан алтан сэнтий тавин хааныг дээр¹ нь суулгаад сэлмээ сугалан өмнө нь тавьцгааж: "Бүгдийн хаан болтугай хэмээн бид хүсэж, гуйж, бас тушааж байна" хэмээжээ. Тэрээр цугларагсадад хандан: "Хэрэв та нар намайг цөмийн чинь хаан болоосой гэж хүсэж байгаа юм бол тушаасны минь хийж, дуудсан цагт минь ирж, илгээсэн зүгт минь явж, алсугай гэсэн хүнийг маань алахад бэлэн байна уу?" хэмээн асуувал тэд бэлэн гэж хариулсан байна. Тэгэхэд нь тэрээр: "Миний тушаал бол миний сэлэм байх болно шүү..." гэжээ. Дараа нь түүнийг эсгий дээо суулган: "Дээшээ тэнгэр өөд харж Бурханыг олж мэдтүгэи, доошоо харж

өөрийнхөө суусан эсгийг үзсүгэй. Хэрэв сайн хаан болж шударга өгөөмөр байвал...ертөнц тэр чигээрээ өмнө чинь сөгдөж, дотор санаандаа хүссэн санасан болгоныг чинь Тэнгэр бурхан илгээх болно. Хэрвээ ингэж эс чадваас аз жаргалаас ангижирч, ад шоо үзэгдэн одоо дээр нь сууж байгаа эсгий хүртэл эргэж олдохгүйгээр ядуурах болно" гэж хэлээд гэргийг нь хаантай зэрэгцэн суулгаад хоёуланг нь дээш өргөж ..."Хамаг Монголчуудын хаан, хатан хоёр болой" хэмээн тунхаглажээ.

Чингис хааны ач хүү Гүюгийг 1246 онд хаан өргөмжилсөн ёслолыг Францискан дипломатчийн дагуул, Польш гэлэн Венедикт ийнхүү бичсэн байдаг. Эл ёслол 40 жилийн өмнөх ёслолын нэгэн адил байсан биз ээ.

Их хааныг өргөмжлөн сонгосны дараа цагаан адууны сүүл бүхий өндөр ишийг тойрон арай намхан найман тугийг байрлуулсан есөн хөлт цагаан туг -сүлдийг хуралдагсдын дээгүүр өргөн мандуулав. Урьд нь энэ туг сүлд Тэмүүжин хааны овгийн онгон шүтээнд тооцогдож байсан бол ийнхүү хормын өмнө төрөн мэндэлсэн нийт Монгол үндэстэн, гүрэн улсын бэлгэдэл болон хувирлаа. Боржигин овгийн даруухан удирдагч түүх болон улиран одож, газар орнуудыг хураан эзлэгч аугаа хүн дэлхийн давцанд гарч ирлээ. Овог аймаг хоорондын дайн дажны 20 жил ард хоцорсон бөгөөд Евразийг байлдан дагуулах ажил өмнө хүлээж байв.

НУУЦ ТОВЧОО

Чингис хаан өргөмжлөгдөн гарч ирж, Монгол төр улс үүсэн бүрэлдсэн үйл явдлыг "Монголын нууц товчоо" шаштирт бичиж үлдээсэн байдаг нь бидний их аз билээ. Монголын Юань улсын албан ёсны түүх "Юань улсын судар"-ыг бодвол энэ шаштир Бээжин дэхь эзэн хааны номын сангийн нууц архивт олон зууны турш далд байжээ. Энэхүү эх бичвэрийг Оросын иеромонах Палладий (Кафаров) дөнгөж XIX зуунд европчуудад олж нээж өгөн Монголчууд болон Чингис хааны тухай мэдээ сэлтүүдийн гол их сурвалж болгосон юм. Эл шаштирын бичигдсэн цаг хугацааны талаар одоо ч гэсэн мэтгэлцсээр байгаа бөгөөд өдгөө олон эрдэмтэд "МНТ"нь 1228 онд Чингис хааныг залгамжлагчийг өргөмжилсөн хуралдайн үед бичигдсэн, харин ганцхан бүлгийг л сүүлд нэмж бичсэн байна гэсэн бодолтой байх болжээ.

Ачаа тэрэг, гэр, мянга мянган адуу мал багширсан тал нутаг байна гээд төсөөл дөө. Монголын эзэнт гүрний газар бүрээс Хуралдайд ирсэн Чингисийн алтан ургийн хаад ноёд тэргүүтэй дайчид шөнө түүдгийн дэргэд сууцгаана. Ердөө хориодхон жилийн өмнө их хаан төр улсаа бичиг үсэгтэй болгоод байсан ба өөрөө тэрээр бичиж ч, уншиж ч сураагүй ажээ. Ярианы хэлний соёл асар өндөр байсан учир "Монголын Нууц Товчоо" шаштир энэхүү түүдгийн дэргэд өрнөсөн яриа хөөрөөнүүдийг бичгээр үлдээж хоцроосон мэт бодогддог. Хэн нэгэн хүн цэргийн байрлал дундуур яван чагнаж байх мэт. Залуу Тэмүжиний тухай туулийг туульч хайлан "Нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой" гэж байх шиг, тэртээ тэнд мөргөн бөө Бөртэ чоно Гоо марал хоёроос эх авсан Монголчуудын өвөг дээдсийн үүх түүхийг хүүрнэж байхад өөр нэг газарт хуучин цэрэг эрс хийж байсан халдлага довтолгоонуудынхаа тухай ам уралдан ярьж байх ажээ.

Энэхүү он дарааллын бичигт хүүрнэл яриа хийгээд яруу найраг байлдаан тулалдааны олон өнгийн дуу чимээ товчхон илтгэл зэрэг цаг хугацааны дахин давтагдашгүй дуу хоолой болон нийлсэн байх авай. Дэлхийн талыг эзлэн дагуулагч хүүхэд ахуйдаа нохойноос айдаг байсан нь ч эндээс харагдана. Эдүгээ их хаан нас бараад нэг жил хэдийн өнгөрчихөөд байгаач Тэмүүжиний идэр ахуйн анд нөхөд түүний ялалт ялагдлуудыг нүдээр үзэгсэд амьд сэрүүн хэвээр Чингис хаан өөрсийнх нь хувьд бурхан бөгөөд тахил, садан, төрөл хамтран зүтгэгч нь байсан нэгэн үеийн тал нутгийнхан ч амьд байсан ба олон хүний хувьд тэрээр

өрсөлдөгч, ялан дийлэгч нь байлаа.

НИЙГМЭЭС ШААРЛАГДСАН ХҮН

"Тэмүүжин" гэдэг нь монголоор "Төмөрчин" буюу "Төмрийн дархан" гэсэн үг юм. Тал нутгийн энэхүү аугаа их баатар ийм нэртэй болсон нь дайсантай нь холбоотой байв. Дайчин эрсийн зориг баатарлагийг ихэд үнэлдэг, хүчтэй дайсны нь нэртэй хамт түүний хүч чадлын нэг хэсэг хүүхдэд ирдэг гэж итгэдэг ард түмнүүдэд ийм явдал олонтой гардагчлан Чингис хаан эцэг Есүхэй баатар сая төрсөн хүүдээ өөрийн олзолж авсан татаар дайчин Тэмүжин-Үгэгийн нэрийг өгсөн байлаа. Гэвч ингээд ч зогссонгүй, дайсан аймгийн нь нэр Тэмүжиний ард түмний нэртэй нэгдэн нийлсэн билээ.

Татаар нар X-XII зуунд Тал нутгийн овог аймгуудын хамгийн хүчирхэг нэгдэл болоод байв. Татаар олонтой Батын цэрэг "сүүлчийн тэнгис рүү" аян дайн хийснээр энэ нэр Чингис хааны эзэнт гүрний бүх ард түмэнд хамаатах болсон эдгээр аймшигт харийнхныг европчууд монгол-татаарууд буюу зүгээр татаарууд (тартаарууд) гэдэг байлаа. Үнэн хэрэгтээ жинхэнэ татаарууд нь монголчуудын өстөн дайсан байжээ. "МНТ"-нд их хаан өөрөө тэднийг эцэг өвгөдийг минь хөнөөсөн гэсэн байдаг. Тэд л Тэмүжиний дээд өвөг Амбагай хааныг барих Умард Хятадад эзэн суучихаад байсан Зүрчид нарт хүргэж өгснөөр тэд түүнийг Бээжинд аваачин "модон илжигт" хадан гутамшигтайгаар цаазалсан байлаа. Тэмүжинг дөнгөж 8 настай байхад түүний эцэг нүүдэлчдийнхээ дотор ихээхэн нэр хүнд бүхий баатар эрийг татаарууд хордуулж алсан аж.

Тал нутгийн эрх засаглал гагцхүү удирдагчийн нэр хүнд дээр л тогтдог байсан болохоор Есүхэйг үхсэний дараа төрөл¹ садан, харьяат олон нь түүний эхнэр Өэлүнг балчир хүүхдүүдтэй нь орхин, өөр эзэн рүү явсан байна. Чухам л "Сүүдрээсээ өөр нөхөргүй" болж тэд хоцорчээ. Тэр айлд аугаа их өвөг дээдсийн нь тухай дурсамжаас өөр юу ч үлдээгүй бөгөөд оготно зурам алж, өвс ургамлын үндэс түүж, загас барин амь зууж байсан байдаг. Гай зовлон давхар давхар нүүрлэж урьд нь холбоотой байсан тайчууд тэдэн рүү довтлон Тэмүжинг том болоод өс санан хонзонгоо авах байх гэж болгоомжилсны үүднээс олзлон авч одсон байна. "Иим нөхцөл байдалд зөвхөн төмөр мэт хатуу хүмүүс л санаа сэтгэлээр унахгүй байж амжилтийг олох найдлага өчүүхэн төдий байсан ч сайн сайхан төгсгөл рүү тэмүүлдэг билээ. Тэмүжин чухам тийм хүн байжээ" гэж түүхч Г.Вернадский бичсэн байдаг. Хүзүүн дэхь боолын дөнгөөрөө Тэмүжин харгалзаж байсан хүнээ цохиж унагаагаад олзноос зоригтойёо дутаажээ.

Чухамхүү энэхүү амжилт нь тал нутгийн ихэнх хүмүүсийн бишрэн шүтдэг байсан мөнх хөх тэнгэр өөрийг нь аугаа их хувь заяатай болгохоор сонгожээ гэсэн итгэл түүнд бүрмөсөн төрөхөд хүргэсэн байна. Үнэхээр л тэрээр хорвоогийн эгэл бус цайвар шаргал өнгөөр гэрэлтсэн шар үстэй, цэнхэр нүдтэй үл таних нэгэн хүнээс жирэмсэлсэн Алан-гоо эхийн удам шүү дээ. Түүгээр ч үл барам Тэмүжин өөрөө ингэж итгэж байснаас гадна энэхүү итгэл үнэмшилээ өөрийн дүү нар, анд нөхөд, боржигин овгийнхон, монгол овог аймгууд, эцэст нь тал нутгийн бүх хүмүүст өгсөн байв. Түүний аугаа их хувь заяа юм бүхнийг нь, арван гурван настай балчир хүүд захирагдахыг хүсээгүй эх ондоотой дүүгээ алсныг, мэргэд аймгийнхныг довтлоход ирээдүйн хаан эхнэр Бөртэгээ зөнд нь орхин тэдэнд хүчиндүүлснийг нь зөвтгөн цайруулсан болой.

ЭРХ МЭДЭЛД ДУРЛАГЧ

Тэгэхээр зорилгодоо л хүрч байвал ямар ч арга хэрэгсэл сайн болой. Дээр өгүүлсэн золгүй Бөртэгийн инжинд ирж, тэр айлын цорын ганц үнэт зүйл болсон булган дах Хэрэйд

аймгийн нөлөө бүхий удирдагч Тоорил ханд хүрэх замыг Тэмүжинд нээж өгчээ. Тэр үнэ цэнэтэй бэлэг аваад урьд нэгэн цагт Есүхэй баатартай андын барилдлагатай байснаа эргэн санаж хүүд нь "хууль ёсны" эрхийг нь эргүүлэн өгч монголчуудыг нь захируулахаар шийдсэн байна. "Булган дахны чинь хариуд бутарсан улсыг чинь бөөгнөрүүлж өгье. Хар булган дахны чинь хариуд хагацсан улсыг чинь хамтатгаж өгье". Ийнхүү үнэт дах түүхэнд гарсан улс төрийн хамгийн сонин өсөлт өндийлтийн эхлэлийг тавьсан байдаг. Тоорил хан болон өөрийн анд Жамуха нарын тусламжтайгаар Тэмүжин эцгийн өв хөрөнгийг эргүүлэн авч мэргэд нарыг залхаан, аз хийморьтой удирдагч хэмээн алдарших болов. Өндөр их эрх мэдэлд хүрэх замын эхний алхам нэгэнт хийгджээ. Гэвч Тоорил ханы залуу хараатад энэ нь арай бага байсан учир тэрээр цааш өгсөж өндийхийг шаргүй эрмэлзэн зүтгэв. Мэргэдүүдийн дараа татарууд бут цохигдож, улмаар урваж одсон тайчуудын ээлж болсон байна.

Тэмүжин хамтран зүтгэгчдээ няхуур гэгч нь шилж сонгож байлаа. Тэрээр ерөөсөө андын холбоо, нөхөрлөлийг ихэд үнэлдэг ч өөрийнх нь манлайлах эрхийн талаар эргэлзэх хүн гарвал тэр даруй зэвсэгээ тэдний эсрэг чиглүүлдэг байв. Түүний "анд" Жамуха ч, "хуурай эцэг" бөгөөд тэр үед Умард Хятадад ноёрхож байсан Зүрчид нараас "ван" цол хүртээд байсан Тоорил ч энэ тавилангаас зайлж чадсангүй. Тал нутагт шатаж байсан дайны дөл "МНТ" шаштирын хуудаснаас биднийг чухам л хуйхлах шахаж байдаг билээ. Эл дайнд аз хийморь тогтвортой бус, хэдэн мянган цэрэгтэй өчигдрийн ялагч гэнэтхэн ганцаардан туйлдах нь олонтаа. Нэг удаагийн бүтэлгүйтэл, нэг удаагийн дайсны дайралт, юм бүхэн дээсэн дөрөөн дээр байв. Олзлогдогсдыг нэг бол өөрийн цэрэг болгоно, эсвэл цаазална, дундаж зам гэж байсангүй.

Чингис хаан цэрэг улс төрийн дэвшил мандалынхаа хамгийн хүнд үеийг, "тал нутгийнхнаа хурааж" цуглуулах тэрхүү цаг, хэдэн арван удаагийн тулаан гэж үзэж байснаас биш, Хятад болон Дундад Ази руу хийсэн алдарт аян дайнуудаа гэж бодож байсангүй. Тэмүжин нэг бус удаа ялагдал хүлээж байжээ. Жамухатай анх тулалдахдаа л дийлэгдсэн бөгөөд Чингис хааны өөрийнх нь хожим дурсаж байсанчлан "намайг зээрэн хавцалд хөөж оруулан ихэд айлгаж байсан" байна. 1201 онд Хүйтэн уулын дэргэд болсон тулалдаанд дайсны сум Тэмүжиний гүрээний судсыг оносон байдаг. Цус асгаруулсан их тулалдаан шөнө зогсож, үймээн самуун дунд шархтай тэрээр хэдхэн бие хамгаалагчтайгаа үлдсэн байлаа. Хэн нь хэнийгээ ялсныг хэн ч мэдэхгүй байв. Бага залуу насны нь анд Зэлмэ ухаан алдаж байгаа эзнийхээ "муу цусыг" бүхэл шөнийн турш сорж асгаж байснаа дайсны хүрээнд нэвтрэн орж айраг цэгээ авчиран түүний амны цангааг гаргасан байна. Өглөө нь дайсан этгээд дэлхий дахины түүхийн явцыг тун ч амархан өөрчилж чадах байснаа огтхон ч мэдэлгүй гэнэтхэн үймэн сандран ухарчээ.

Чингис хаан аугаа их төрийн хүнд байх бүхий л шинж чанаруудыг агуулж байснаараа авьяаслаг жанжин Жамуха, талын зальт хөгшин үнэг Тоорил ван болон тэр үеийн бусад зүтгэлтнүүдээс ялгаатай байв. Монголчуудын их хаан хожмийн нэгдүгээр Петрийн нэгэн адил ялагдахдаа цөхөрч гутардаггүй, харин ч үнэт сургамж олж авдаг байлаа. Жишээлбэл, урьд нэгэн цагт мэргэдүүдийн дайралтанд өртөснийхөө нэгэн адил дахин гэнэдэж довлуулахгүйн тулд тэрээр өдөр шөнөгүй хүрээ хотыг нь манаж байх тусгай цэргийг бий болгосон байдаг. Үүнээс чухал нэг зүйл бол Тэмүжин хуучин ёс журмын дагуу сайн тоглохын оронд шинэ ёс жаягийг бий болгож байсан явдал мөн.

Энэ дархан тал нутгийн шинэ ёс суртахууныг урлан бүтээжээ. Дээд удирдагч ноёндoo чин үнэнч байх явдал овог аймгуудын мөргөлдөөнөөс дээгүүр, харьяа эзэн ноёноо чөлөөтэйгөөр сонгох явдлаас дээгүүр, гомдож цөхрөөд юмуу, аз хийморь нь харьснаас эзнээ орхин одохоос дээгүүр байдаг болов. Ван ханыг дутаахад нь тус болж арыг нь хамгаалан үлдсэн Хадабаатарыг түүн дээр авчирахад Тэмүжин: "Өөрийн ханыг орхихгүй, түүний амийг аврахын тулд байлдсан

эрийг хэн буруушаах вэ? Нөхөрлөж болох хүн байна" гэж хэлж байсан бол Жамухаг барьж авчирсан хүмүүст: "Хаан эзэндээ халдсан хүнийг яаж орхих вэ? Тиим хүн хэнтэй нөхөрлөх вэ? Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлийг нь хүртэл устга" хэмээсэн байдаг.

Тайчуудын Зэв өөрийн аймгийг бүрмөсөн ялагдсаны дараа ирээдүйнхээ их эзэн дээр өөрөө ирж хүйтэнд болсон тулалдааны үед чухамхүү түүний сум хааныг шархдуулсан болохыг үнэнээр нь хэлжээ. "Дайсны хүн дайсагнаж хорлож явснаа нууж худал хэлэх бүлгээ. Гэтэл чи дайсагнаж хорлосноо нуухгүй шударга хэлж байна. Иим хүнтэй нөхөрлөж болно" гэж Тэмүжин хэлээд хатуу чанд, цэх шулуун тэр дайсныг дотно нөхрөө болгосон байдаг. Зэв ноён ийнхүү Чингис хааны "үнэнч нохой" эзэнт гүрний алдарт жанжнуудын нэг болжээ. Чухамхүү тэрээр л домогт Сүбээдэй баатрын хамт Хорезмаас Перс, Кавказаар дамжин Доны тал нутагт хүртэл түүхэнд огт байгаагүй морьт аян хийж, тагнан турших зорилготой баг цэргийнхээ хүчээр Калк гол дээр Орос -Кипчакуудын нэгдсэн их хүчийг бут цохисон бөлгөө.

Гэхдээ Тэмүжин мөнх тэнгэрээс сонгогдон соёрхогдсон өөртөө өөрөө үнэнч байх явдлыг Тэмүжин үнэнч зан чанар, уужим сайхан сэтгэлээс илүү дээгүүр тавьдаг байв. Хүүхэд ахуй цагийн нь анд, хүнд хэцүү он жилүүдэд түүнд хүчээ өгч байсан эгэл жирийн хүмүүсийн нэг нь ч түүнд мартагддаггүй байлаа. Ван ханы заль мэхээс түүнийг аварсан хоёр адуучин урьд сонсож байгаагүй их хүндтэлийг хүлээж, аян дайнаас олсон олзоо" нийгмийн тогоонд" өргөх буюу, харин өөрсдөө авч байх соёрхол хүртсэн билээ. Нөгөө талаас садан төрөл, ах дүүсдээ ямар ч хөнгөлөлт тал тохой тэрээр үзүүлж байсангүй. Өөртэй нь адилхан цус судсаар нь гүйж байгаа тэр хүмүүст (мөн өөртөө ч гэсэн) Тэмүжин харин ч илүү хатуу ханддаг байлаа. Эцэг нэгт дүү, алдарт дайчин Бэлгүйтэйг татаар нарыг аймаглан устгахаар зэхэж байгаа нууцыг задруулсны нь төлөө тэрээр насаараа хуралдайд оролцох эрхгүй болгож шийтгэсэн байна.

Ийнхүү нүүдэлчид "Мөнх тэнгэрийн ивээл соёрхол хүртсэн хүн" өөрсдийн нь хаадаас хавьгүй илүү анд нөхөр, ивээн тэтгэгч, удирдагч болохыг олж харжээ. Тэрээр үнэнч нөхөрлөл, мэргэн зөвлөгөөг хүлээж авах, үнэлж цэгнэхэд бэлэн байдаг, эрүүл саруул ухаантай, өгөөмөр ханддаг байв. Харгис хатуу байсан нь ч үнэн, гэхдээ ер нь тэдний хэн нь зөөлөн байсан юм бэ? Өөр хоорондоо дайсагнагч овог аймгуудын хэврэг тэнцвэр, эвлэрлийн оронд Тэмүжин хатуу засаглал, эрх мэдлийн дор нэгдэх цөмөөрөнд нь ашигтай зүйлийг бий болгож байгааг Тал нутаг аажмаар ухаарч эхэлжээ.

Чингис хааныг зөвхөн ард олны сайн сайхны төлөө санаа зовнисон "сайхан хаан" мэтээр төсөөлөх нь буруу юм. Эрх мэдэл түүний шунан дурладаг зүйл, өөрт нь ихээхэн цэнгэл таашаал өгдөг эд байжээ. Их хаан аз жаргалын талаар ноёд жанжнуудтайгаа ярилцаж байсан талаар Персийн түүхч Рашид-ад Дин бичиж үлдээсэн байдаг. Хамгийн дээд цэнгэл гэдэг бол аргамаг сайн хөлөг морь унаж, ан ав хийн давхих явдал гэж тэд үзсэн байхад Чингис хаан түүнийг нь үл зөвшөөрөн: "хүний дээд зэргийн цэнгэл бол ялалт юм, дайснаа ялан дийлж мөрдөн хөөж, өмч хөрөнгийг нь булааж аван, дотно хайртай хүмүүсийг нь цурхиртал уйлуулж, хүлэг морьдыг нь унаж, охид эхнэрүүдийг нь тэврэх явдал мөн" гэж хэлжээ. Энэ нь Сталины хэлсэн: "хамгийн дээд амьдралын баяр цэнгэл гэдэг бол дайснаа соргоогоор олж харан, бүгдийг сайтар бэлтгэн, хайр найргүй өшөө хонзонгоо авчихаад явж унтах явдал" гэсэнтэй агаар нэгэн болой.

Тэмүжин ч ялалт амжилтуудаар дүүрэн цэнгэж байжээ. Татаар, мэргэд, хэрэйд, найман гэсэн монгол хэлтэн 4 том аймаг ар араасаа бут цохигдов. Энэ бүхний эцэст 1206 оны Хуралдайгаас шинээр өргөмжлөгдөн Чингис хаан гэгдэх болсон их хаан өөрийн нь аймгийн Монголчууд гэдэг нэрийг авсан тал нутгийн нэгдсэн үндэстэн бий болсныг зарлажээ.

"Чингис хаан" гэдэг энэ нэр, цолны талаар өнөө хүртэл мэтгэлцээр байна. Үүний түрэг хэлний "денгиз" буюу "тэнгис" гэсэн үгнээс гаралтай, тэнгис далай мэт хязгааргүй гэсэн утгатай гэж нэг хэсэг нь үзэж байхад Хятад хэлний "Чжэнь" буюу "үнэнч",

"жинхэнэ" гэдэг үгнээс гаралтай "жинхэнэ хаан" гэсэн утгатай үг гэж нөгөө хэсэг нь үзэж байгаа юм. Гурав дахь хэсэг нь Ойрдын "Чингис" буюу "чийрэг, бат бэх" гэсэн үг гэж үзэж байх ажээ. Хамгийн сонирхолтой тайлбарыг түүхч Э.Хара-Даван өгсөн байдаг агаад эртний монгол хэлэнд энэ үг нь их хааны бие мах бодын болон оюун санааны хүч чадлын хослолыг илэрхийлсэн байна гэж тэрээр үзжээ. Гэвч их хааныг тэнгэрт хальсны дараа түүний нэрийг дурдахаас цээрлэх болсноор аажимдаа мартагдсан байна. Ямар ч байлаа гэсэн энэ шинэ нэр үймээн самуунтай цаг үеийн шинж байдлыг бэлгэдэхийн хамт эзэнт гүрэн үүсэн бий болж түүний эзэн хаан хязгааргүй эрх мэдэлт их эзэгнэгч болон хувирсныг илтгэх болжээ.

ХУУЛЬ ТОГТООГЧ

1206 оны Хуралдай дээр Чингис хаан шинэ төр улсынхаа үндэс суурийг тавьсан бөгөөд түүнийг хүн бүгд сахин мөрдөж байх ёстой нэгдмэл цогц хууль болох Их засаг болгон томъёолжээ. Хамгийн түрүүнд нүүдэлчдийн мянган жилийн туршлагад тулгуурлан цэрэг армиа шинэчилсэн байна. "Нүүдэлчдийн төр улс гэдэг бол аялж яваа арми мөн" гэж түүхч Михаил Геллер маш оновчтой хэлсэн байдаг. Урьд нь ч гэсэн байсан аравт, зуут, мянгатад хуваадаг систем дээр нэмж хамгийн хүчирхэг нэгж болох түмт буюу арван мянгатыг бий болгосон байна. Монгол цэрэгт байсан 95 мянганы ноёдыг Чингис хаан өөрөө биечлэн томилсон бөгөөд "Монголын Нууц Товчоо"-нд үүнийг нэг бүрчлэн дурдан тоочсон байдаг. Зуутын захирагчаас эхлэн бүх ноёд тогтсон хугацаанд заавал ирж их хааны заавар зарлигийг сонсвол зохино гэж Засаг хуулинд заажээ.

Тухайн хүний зориг зүрх, алдар гавъяаг тэргүүн зэрэгт тавьдаг рыцарь баатаруудын цэрэг армиас ялгаатай нь гэвэл Чингис хаан цэрэг дайчдынхаа боломж бололцоог сайн мэддэг хашир хэрсүү зан чанарыг жанжнуудынхаа хувьд ихэд дээдэлж үнэлдэг байжээ. Жишээлбэл, тэрээр өөрийн хамгийн шилдэг баатар, ойрын төрөл Есүгэ баатарт томоохон баг цэрэг захирах ажлыг даатгахгүй, өөрөө өлсөж цангаж, эцэж цуцахыг огт мэдэхгүй учир дайчдаа туйлдуулчихна хэмээдэг байсан байна.

Засаг хуулинд зааснаар цэрэг эрх зөвхөн дайны үед төдийгүй, мөн тайван цагт аж ахуйгаа эрхэлж байхдаа тушаалгүйгээр өөрийн байрыг орхиж явахыг хориглосон байдаг. Язгуур угсаа, хөрөнгө чинээнээсээ үл хамааран цөмөөрөө төр улсынхаа төлөө ажиллах ёстой байсан учраас чухамдаа бүх талаар хүчин зүтгэх зарчмыг баримталж байжээ. Ноёд, түшмэлүүд хэдийгээр урьдын гавьяа их боловч ажил албаа мэдэхгүй байвал язгуур угсаанаасаа үл хамааран даруй огцордог байв. Ажил алба, төмөр мэт сахилга бат нь монголчуудыг дээрээс нь аван доор хүртэл адил тэгш болгож, нэгэн хүчирхаг нударга болгон зангиддаг байсан байна.

Хааны хишигтэн цэрэг хэмээх нэгэн түмэн хүнтэй тусгай шигшмэл цэрэгтэй болсон явдал маш чухал үйл хэрэг байлаа. Мөн ийм зарчим баримталж байсан Наполеоноос олон зууны өмнө Чингис хаан энгийн цэрэг эрс дотроосоо хамгийн шилдэг цэрэг, ноёдыг шилж аван хишигтэн цэргээ бүрдүүлснээр тэр нь нийт армийн төлөөлөл болжээ. (Чухамдаа зуут, мянгатын ноёдын хөвүүд л хишигтэн болдог байв). Дайн тулааны үед эдгээр шилдэг дайчид их хааны өөрийн нь удирдлагын дор нөөц хүч болох бөгөөд үүний үр дүнд хишигтэн цэргүүд хүчээ хайрлан хямагдахын зэрэгцээ захирагч нарыг бэлтгэх сургууль болдог байжээ. "Хишигтэн" цэрэг түмтээс бусад цэргийн ямар ч анги, хэсгийг захирах эрхтэй байсан аж. Цаашилбал, Чингис хааны хишигтэн цэргүүд Петровын семеновчууд болон Преображенскийчүүдтэй адил зөвхөн цэрэг дайны болон дипломат төдийгүй, мөн засаг захиргааны шинжтэй даалгавруудыг хаанаасаа авч гүйцэтгэдэг байсан байна. Энгийн хишигтэн цэрэг гадны мянгатын ноёдоос дээгүүр байлаа. Гадна цэргийн ноёдын хөвүүд болох хишигтэн эрс зөвхөн Чингис хаандаа үнэнч байж, өөрсдийн эцгүүдийн байдалд хяналт

тавьдаг байсан ажээ. Тал нутагт бий болсон энэхүү шинэ журам тун ч чухал түшиг тулгууртай байлаа.

АНЧИН

Засаг хуулинд ан авын тухай тусгай заалт оруулсан нь цэрэг дайчдыг бэлтгэх үйл хэрэгт энэ нь тэргүүлэх үүрэгтэй болохыг бататгаж өгсөн байдаг. Хоморго ав нь биеийн тамирын наадам цэнгэлтэй гэхээсээ илүүтэй, асар том байлдааны ажиллагаатай төстэй байжээ. Энд Монголчуудын тактикийн гол арга барил болох их цагираган бүслэлтийг сургуулилдаг байв. Тандуулууд араатан амьтдыг мөрдөн мөшгиж олдог ба тэдний өгсөн мэдээний үндсэн дээр өвөл болсны дараа морьт цэрэг хэдэн мянган км квадрат талбай бүхий газар нутгийн амьтай бүхнийг хамж битүү цагаригт оруулна.

Авд оролцогчид төв, хоёр жигүүр болж цэргийн зохион байгуулалтанд ордог байсан ба жинхэнэ байлдаж байгаа мэт зуут, мянгатуудаа тус тусын ноёд нь захирна. Гурван сарын турш аажмаар хумигдах эл цагаригийн гадна их хааны өргөө байрлана. Агнах амьтад тойргийн голд бөөгнөрсний дараа тойруулан оосор уяа татаж хаших ба гадагш гаргаж алдсан хүнийг хатуу цээрлүүлдэг байв. Дараа их хаан зүсэн зүйлийн амьтад холилдон үймэлдэх талбайд орон тойрч яван сонголтоо хийж эхний сумаа тавьдаг байна. Түүний дараа их хааны ураг удмынхан, хишигтэн нар, шадар жанжин ноёд зэрэг зиндаагаа чанд баримтлан харвах ба хамгийн сүүлд жирийн цэрэг дайчид харвана.

Хэдэн өдөр ийнхүү авалсны эцэст настангуудын төлөөлөгчид их хаан луу очиж үлдсэн араатан амьтдыг өршөөхийг түүнээс гуйснаар амьд буй амьтдыг тавьж явуулдаг ажээ. Алагдсан ангийн махыг эртний заншил ёсоор авд оролцогчдод цөмд нь хувааж өгнө. Үүний дараа их хаанаас цэргийн ээлжит бэлтгэл сургуулилт дуусгавар болсныг зарласнаар ав дуусна.

ӨРХИЙН ТЭРГҮҮН

Цэрэг армитай дүйцэхүйц чухал төрийн бас нэг институт бол их хааны гэр бүл гэж Их засагт заажээ. Чингис хааны үр ач нар буюу хожим нэрлэсэнчлэн "Аптан ургийнхан" хувь эзэмшил нутаг аяндаа олж авдаг байсан бөгөөд тэр нь зөвхөн нүүдэллэн явах бэлчээр нутаг төдий бус, басхүү захирагдах харъяат ард олон, мал сүргийг багтаасан байжээ. Бусдыгаа захирч байсан ихэс дээдсийн орд өргөөнүүд цөм хязгааргүй их тал нутгийн энэ эцэнт гүрний жинхэнэ нүүдлийн хотууд, хөдөлгөөний тулгуур цэгүүд байсан юм. Тэдний нүүж буух нутаг дэвсгэр нь чухамдаа цэргийн тойрог буюу хүрээнүүд байсан агаад зүй нь зуун оршин суугч тутам арван даичныг агт морьдын нь хамт, мянган хүнээс зуун цэргийг унаа морьдын нь хамт гэх мэтчилэн нийлүүлэх ёстой байв. 1206 оны Хуралдайгаар Чингис хааны эх Өэлүн хатан хамгийн олон буюу 10000 өрх айлыг хувь эзэмшил болгон авч байсан байдаг. Дашрамд хэлэхэд, эцсийн хяналт, дахин хувиарлах ажил ямагт их хааны мэдэлд байсан байца. Түүнээс гадна жилд нэг удаа алтан ургийнхан ноёд жанждынхаа өргөн барьсан эд зүйлийн хамт цугларан Засаг хуулиа хэн ч зөрчөөгүй гэдгээ харуулдаг байжээ. Зөрчсөн этгээдийн эрх ямбыг хурааж, даруй цаазалдаг байв.

Эзэнт гүрний үзэл санаа өөрөө Чингисийнхний онцгой, сонгогдмол шинж чанарт үндэслэсэн байлаа. Мөнх тэнгэр бүхнийг Дэлхий ертөнц дээр шударга засаглалыг тотоох үүрэг гүйцэтгэгчээр сонгосон байсан агаад эл ажлын эхний шат нь Монгол, дараагийнх нь дэлхий тэр аяараа байв.

Их хааны зарлиг тушаалыг эс дагасан ард түмэн болгоныг самуун дэгдээсэн босогчид гэж үзнэ хэмээн Засаг хуулинд шууд өгүүлсэн байдаг ажээ. Энэ орчлонгийн бүх үндэстнүүд

өөрсдөө мэдэхгүй байлаа ч гэсэн Дэлхийг хамарсан их гүрэн улсын харъяат хэмээн зарлан тунхаглагдсан байлаа. Түрэмгийлэл гэж бидний одоо үзэж байгаа тэр зүйлийг Тэмүжиний хамтран зүтгэгчид өөрсдийн жам ёсны эрх төдийгүй, мөн албан үүрэг гэж үзэж байсан

байдаг. Үймээн самуун дэгдээгчдэд: "Та нар сайн дураараа бууж өгөх аваас амар амгаланг олох болно. Хэрэв та нар эсэргүүцэн тэмцэлдвээс юу болохыг гагцхүү Мөнх тэнгэр мэдэхээс бид эс мэднэ" гэсэн үгтэйгээр элчийг томилон илгээж байхаар Засаг хуулинд заасан байлаа. Их хааны элч нарт учруулсан аливаа хор хөнөөл, ялангуяа тэднийг алах явдалд монголчууд хатуу ял шийтгэл ногдуулж, "эсэргүүцэн тэмцэгчид" нь өндөр дээд хүчийг эсэргүүцэж байгаагийн анхны шинж тэмдэг, тийм ч учир "амар амгалан, энх тайван" амьдрах ёсгүй гэж үзэж байв.

Ийнхүү Чингис хаан монголчуудын хувьд аугаа зөнч, Дэлхий ертөнц дээр дэг, журам тогтоох бурхны зэр зэвсэг байлаа. Харин бусад хүмүүсийн хувьд тэрээр Бурхны ташуур байсан билээ.

ЗАСАГ ХУУЛЬ

Эл цогц хууль эзэнт гүрний амьдралын бүх талыг харуулдаг байлаа. Чингис хаан зарлигаар ялагдсан найман аймгаас авсан уйгар цагаан толгойд үндэслэн зохиогдсон бичиг үсгээр энэхүү анхны цогц аман хууль дүрмүүдийг бичиж авсан байна. Их хааныг залгамжлагчид Засаг хуулийн ид шидийн хүчтэй гэдэгт итгэж эзлэгдсэн болон эрх чөлөөт харийнхны нүднээс энэхүү "ариун номоо" далд байлгадаг байв. Байлдаан тулалдаанд ялалт авчирдаг гэж түүнийг үздэг байжээ. Харамсалтай нь, энэ хууль бүрэн бүтнээрээ үлдээгүй боловч эртний түүхчдийн бүтээлд олонтаа дурдагдсан байдлаар нь түүний мөн чанарыг ойлгон авч болохоор байдаг.

Цэрэг арми болон ан авын тухай заалтуудаас гадна уг хуулинд эрүүгийн болон татварын холбогдолтой зүйл заалт, худалдааны эрх зүйд хамаарах зүйлүүд болон иргэний хуулиуд байгаа юм. Зарим нэгэн гэмт хэргийн төлөө занчиж залхаах юм уу, торгууль ногдуулдаг хэдий ч үндсэн шийтгэл нь цаазлах ял байсан ажээ. Гурван удаа өр тавин авч гурвантаа дампуурсан худалдаачдыг ч цаазалдаг байсан байна.

Засаг хуулийн философи нь зөрчигсдийг устгаж үгүй болгох замаар энх амгалан, хэв журам тогтооход оршиж байлаа. Энэ үүргийг Чингис хаан хуурай дүү Шихихутугийн тэргүүлж байсан Төрийн заргачийн алба (Дээд шүүх) байв. Шихихутуг монголчуудаас анх бичиг үсэгт суралцсан, хээл хахуульд автдаггүйгээрээ алдартай хүн байсан ба "Монголын Нууц Товчоо" шаштирыг зохиосон ч гэж яригддаг.

Шүүхээс гадна өөр олон, шинэ зүйлийг Чингис хаан бий болгосон юм. Жишээлбэл, аянчид унаа морьдоо сэлгэж байх өртөө буудлуудыг дурдаж болно. Хааны элч төлөөлөгчид, гадаадын элчин нар, худалдаачид үнэ төлбөргүйгээр өртөөг ашиглана. Буухиа элч нар галт тэрэгний хурдаар тал нутгаар давхина. (Их хааны элч нарын бүсэнд хонх зүүсэн байх агаад дараа дараагийн буудлууд дээр хонхны чимээг урьдаас сонсон буухиа авах элчийг зэхдэг байв.)

Нийгмийн дээд хэсгийнхний хатан болох сүйт бүсгүйчүүдийг сонгох журмыг ч тогтоон заасан байна. Монгол айл өрх болгон охид хүүхнүүдээ жил болгон хааны ордон луу илгээж шалгаруулалтанд оруулдаг байсан, түүнд тэнцсэн гоо бүсгүйчүүд хаан болон түүний ургийнхныг эр нөхрөө болгох боломж олдог байжээ.

Гэвч Чингис хаан ухааны цараатай хүн байсан болохоороо эл дүрэм журмын гажилтыг нь ч бас бодолцсон байв. Жишээлбэл, Засаг хуулийн татварын заалтууд нь алба

гувчуур улсын санд авдаг байх хатуу систем тогтоохын хамт аливаа шашин ном, сүм хийдийнхэн өндөр чадвартай урчууд, зураачдыг бүх төрлийн алба гувчуураас чөлөөлдөг байсан бөгөөд цаадуул нь их хааны төлөө мөргөл залбирлаа үйлдэн, ур чадвараараа түүнийг алдаршуулах ёстой байлаа.

Ер нь тэр үед огт сонстож байгаагүй хэмжээнд Засаг хуулиар аливаа шашин шүтлэгийг хүлцэн тэвчих явдлыг тунхагласан байв. Өөрөө Мөнх хөх тэнгэртээ залбиран шүтдэг Чингис хаан несториан чиглэлийн христийн шашинтнууд, буддын шашинтнууд, лалын сүсэгтнүүдийн аль аль нь байсан харъяат нартаа өөрийн сүсэг бишрэлийг огт тулгадаггүй байжээ. Хэдий тийм боловч эзэнт улсын оршин суугчид цөм нэг шашин шүтлэгтэй байх шаардлагатай байсан ба энэ нь их хааны өөрийн нь бурханлаг чанарт итгэх явдал байв.

Персийн түүхч Рашид-ад Диний бичсэнээр монголчуудын хувьд "Чингис хаан бол Орчлонгийн эрхсийн бурхан, газар дэлхий, Цаг хугацааны хаан байсан ба бүх монгол овог аймгууд цөм түүний боол, зарц нар болсон байлаа. "Оросын ван Черниговын Михаил асаасан хоёр галын хоорондуур гарч, их хаанд өвдөг сөгдөн, Чингис хааны барималд мөргөхөөс татгалзсаных нь төлөө цаазалсан байдаг. Монголчуудын тухайд дээрхээс илүү нүгэл гэж үгүй байлаа.

ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН

1162 оны орчим -Ирээдүйн Чингис хаан, Тэмүжин төржээ.

1202 он -Тэмүжин Ван хантай нэгдэн татаартай байлдав.

1206 он -Тэмүжин монгол овог аймгуудын цөмийг нь нэгтгэн өөрийн захиргаанд оруулж, Хуралдайгаас Чингис хаан цолоор өргөмжлөгдөв. Засаг хуулийг тунхаглажээ.

1207-1211 он -Сибирь болон Дорнод Туркестаны буриад, якут, Ойрад, Киргиз, Уйгур аймгуудыг эрхшээлдээ оруулж тангуудын Си-Ся улсын эсрэг аян дайн хийв. (Энэ улс 1227 онд бүрмөсөн эзлэгджээ)

1211-1215 он -Монголчуудын гадаад түрэмгийлэл эхлэв

Чингисийн цэрэг Умард Хятадын Цин улсад халдаж 90 орчим хотыг нь сүйтгэв, 1215 онд Бээжин унажээ.

1217 он -Хятадын Шар мөрнөөс хойших нутаг бүхэлдээ эзлэгдэв. 1218-1224 он -Монголчууд Хорезмыг довтлон байлдлаа.

1218 он -Монголчууд Долоон галыг / Казакстан/ эрхэндээ оруулав.

1219 он Чингис хаан тэргүүтэй 100000 цэрэг Дундад Ази руу цөмрөн оржээ.

1221 он-Хорезмыг эзлэн авч Дундад Азийн байлдан дагуулалт дуусав. Орчин үеийн Делийн султант улс руу аян дайн хийжээ.

1223 оны 5-р сарын 31 -Зэв, Сүбэдэй нарын 30000 цэрэг Калк гол дээр орос-кипчакийн цэргүүдийг ялжээ.

1227 он -Чингис хаан нас барав. Хоёр жилийн дараа Өгэдэй их хаанаар (1229-1241) өргөмжлөгджээ.

"Вокруг Света", № 5/2788/, 2006 сэтгүүл "Түүхийн
оньсого" булангаас доктор, (Ph.D) дэд профессор
С.Одхүү орчуулж, хэвлэлд бэлгэсэн